

UCS 1401C:2020


НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ



Гадна мэдээллийн байгууламжид тавигдах
ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Гадна мэдээллийн байгууламжид
тавигдах ерөнхий шаардлага



ГАРЧИГ

1. Зорилго	1
2. Хамрах хүрээ	1
3. Норматив эшлэл	1
4. Нэр томъёо, тодорхойлолт	1
5. Төлөвлөлтийн ерөнхий шаардлага	2
6. Мэдээллийн самбар төрөл ангилал	3
7. Мэдээллийн самбарт тавигдах шаардлага	7
7.1. Бичвэрийн шаардлага	7
7.2. Зураглалын шаардлага	7
7.3. Дизайн, технологийн шаардлага	7
7.4. Нэмэлт медиа тоноглол	8
8. Гадна мэдээллийн байгууламж байрлуулах	8
9. Гадна мэдээллийн байгууламж суурилуулах	10
10. Материал, бүтээцийн шаардлага	11
11. Бүртгэл, ашиглалт, засвар үйлчилгээ	12
12. Гадна мэдээллийн самбарыг хүлээн авах шалгуур үзүүлэлт	13
Хавсралт №1 нийтийн эзэмшлийн мэдээллийн байгууламжийн дизайн	14
Ашигласан материалын жагсаалт	15

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах гадна мэдээллийн самбар	2
Зураг 2. Байршлын мэдээллийн самбар. / Жишээ /	3
Зураг 3. Байршлын мэдээллийн самбар. /Жишээ/	4
Зураг 4. Барилга байгууламжийн мэдээллийн самбар	5
Зураг 5. Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн самбар	6
Зураг 6. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар	6
Зураг 7. Ухаалаг мэдээллийн байгууламж	8
Зураг 8. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага	9
Зураг 9. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага	9
Зураг 10. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулах хэсэглэл. /Жишээ /	10
Зураг 11. Мэдээллийн байгууламжийн загвар. / Жишээ /	14

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Мэдээллийн байгууламжийн эдлэхүүний өнгөний төрөл	11
Хүснэгт 2. Хийцлэлийн төрөл, үзүүлэлт	11
Хүснэгт 3. Мэдээллийн байгууламжид хяналт, үнэлгээ хийх чиглэл	12
Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт	13

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Гадна мэдээллийн байгууламжид тавигдах ерөнхий шаардлага

1. ЗОРИЛГО

Энэхүү баримт бичгийн зорилго нь нийтийн эзэмшлийн талбай, үйлчилгээний барилга байгууламжийн ойролцоо байрлуулах мэдээллийн самбарын хийц, бичвэр, зураглалын шаардлагыг тогтоож, самбарыг байрлуулах, суурилуулах, ашиглах үйл ажиллагааг удирдамж арга зүйгээр ханган, хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж, хэрэглэгчдийг үр дүнтэй мэдээллээр хангахад оршино.

2. ХАМРАХ ХҮРЭЭ

Удирдамж арга зүйн баримт бичгийг нийтийн эзэмшлийн талбайд байнга байрлуулах мэдээллийн байгууламжийг төлөвлөх, байршил сонгох, суурилуулах, ашиглах үйл ажиллагаанд дагаж мөрдөнө.

Бизнесийн байгууллагын арилжаа, зар сурталчилгааны зориулалт бүхий самбар, барилга үл хөдлөх хөрөнгийн хаяг болон авто замын тэмдэгт хамаарах үйл ажиллагааг энэхүү баримт бичгээр зохицуулахгүй болно.

3. НОРМАТИВ ЭШЛЭЛ

Энэхүү баримт бичигт дараах эш татсан стандартыг хэрэглэнэ. Эш татсан стандартад өөрчлөлт орсон тохиолдолд тэдгээрийн сүүлийн албан ёсны хэвлэлийг хэрэглэнэ. Үүнд:

- MNS 6775:2019 – Хаяг, Хаягийн бичвэрт тавигдах ерөнхий шаардлага
- MNS 5217:2017 – Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг
- Гадна хаяг, мэдээллийн байгууламжид тавигдах шаардлага батлах тухай Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2014 оны 09 сарын 19-ний өдрийн А/148 тушаал
- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 9/10 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралт

4. НЭР ТОМЬЁО, ТОДОРХОЙЛОЛТ

Мэдээллийн самбар – гэж цаг үеийн шинж чанартай мэдээлэл агуулсан түр байрлуулах самбар бүхий байгууламжийг;

Хаяг байршлын мэдээллийн байгууламж – гэж тодорхой маршрут болон чиглэл заасан шинж чанартай байх бөгөөд түүний төрөлд объектын байршил чиглэл, нийтийн тээврийн маршрут, байгууллагын байршил заасан самбарыг;

Байгууллагын нэгдсэн мэдээллийн байгууламж – гэж Олон аж ахуйн нэгж, байгууллага нэг байшинд байрладаг бол тухайн байшингийн гадна талд байрлуулсан нэгдсэн байгууламжийг;

Түүхэн дурсгал, соёлын үл хөдлөх дурсгал газрын танилцуулга самбар – гэж соёлын өвийг хадгалж хамгаалах, судлах, сурталчлах, ашиглах талаар аялал жуулчлалын чиглэлд зориулсан байгууламжийг;

Барилга байгууламжийн мэдээллийн түр самбар – гэж барилга, объектын талбайг барилга угсралтын ажил явагдаж байгаа хугацаанд хамгаалах, гаднын хүн нэвтрүүлэхгүй байх, хүмүүст сэрэмжлүүлэх зорилготой барилгын түр хашаан дээр байрлуулсан самбарыг;

Түр байрлуулах мэдээллийн самбар – гэж улирлын болон түр хугацаагаар ажиллах нээлттэй үзэсгэлэн, зах, сүүдрэвч бүхий үйлчилгээ, урлаг, спортын арга хэмжээний үед гадаад орчноос ажиглагдахаар байрлуулсан самбарыг;

5. ТӨЛӨВЛӨЛТИЙН ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1. Гадна мэдээллийн байгууламжийг хот төлөвлөлт, хотын архитектур дизайны шийдэл, иргэдийн болон авто замын хөдөлгөөний аюулгүй байдал, хэл бичгийн стандарт, шаардлагад нийцүүлэн барилгын хана, гудамж, талбай болон бусад орон зайд байрлуулах, буулгах, ашиглахад энэхүү тавигдах шаардлагыг үндэслэл болгоно.
- 5.2. Гадна мэдээллийн байгууламжид нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайд зорчиж байгаа иргэд, үйлчлүүлэгчдийг мэдээллээр хангахад зориулан, хотын өнгө үзэмж, иргэдийн эрүүл аюулгүй орчны нөхцөлийг хангасны үндсэн дээр байрлуулна.
- 5.3. Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг өөрийн барилга объектын хана, дээвэрт байрлуулах боломжгүй эсвэл тухайн байгууллагын байршил нь олон нийтэд үзэгдэх орчин хязгаарлагдмал байдлын улмаас нийтийн эзэмшлийн гудамж, талбайд хаяг, мэдээллийн байгууламж байрлуулах шаардлагатай нөхцөлд тухайн нутаг дэвсгэрийн харьяалагдах дүүргийн Засаг даргын тамгын газраас зөвшөөрөл авна.




Зураг 1. Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах гадна мэдээллийн самбар

- 5.4. Мэдээллийн самбарт байрласан мэдээлэх хэсэг нь хүний харааны түвшинд байвал зохино.
- 5.5. Мэдээллийн самбар нь орчин үеийн технологийн шийдлийг ашиглан аудио болон видео дүрст нэмэлт тоноглолоор тоноглогдсон байж болох ба байрлуулах мэдээлэл нь шөнийн цагт мэдээлэл харах боломжийг бий болгож байна.
- 5.6. Гадна мэдээллийн байгууламжид стандарт хэмжээ заахгүй бөгөөд байрлуулах байршил, мэдээллийн агуулга хэмжээнээс хамааруулан эдийн засгийн хувьд хэмнэлттэй байх зарчмыг баримталбал зохино.

6. МЭДЭЭЛЛИЙН САМБАР ТӨРӨЛ АНГИЛАЛ

6.1. Байршлын мэдээллийн самбар

- 6.1.1. Байршлын мэдээллийн самбар гэж нийтийн эзэмшлийн талбайд байршуулсан маршрут болон чиглэл заасан шинж чанартай байх бөгөөд тодорхой объектын мэдээллүүд болон, нэг цэгээс нөгөө цэг хүртэл явган хүн, тээврийн хэрэгслээр туулах замын урт болон хугацааг заасан самбарыг хэлнэ.
- 6.1.2. Байршлын мэдээллийн самбарт тухайн мэдээлэл байрлуулсан цэг, ойролцоох гудамжны нэр, замын сүлжээ, нийтийн тээврийн зогсоолын байршил болон чухал шаардлагатай барилга, үйлчилгээний байршил, зүг чигийг харуулсан байна.
- 6.1.3. Байршлын мэдээллийн самбарыг явган хүний замын гол цэгүүдэд болон нийтийн тээврийн зогсоолын ойролцоо, орчны аюулгүй байдлыг хангасны үндсэн дээр байрлуулсан байна.



Зураг 2. Байршлын мэдээллийн самбар. / Жишээ /

6.2 Байгууллагын нэгдсэн мэдээллийн самбар

- 6.2.1. Байгууллагын нэгдсэн мэдээллийн самбар гэж нэг барилгад олон аж ахуйн нэгж, байрлан, барилгын гадна болон дотор талд байрлуулсан байгууламжийг хэлнэ.
- 6.2.2. Нэгдсэн мэдээллийн самбар нь дараах шаардлагыг хангасан байна.
 - 6.2.2.1. Байгууллагын давхар бүрийг доороос нь дээш нь цувуулан бичиж тухайн давхарт байрлах аж ахуйн нэгжийн лого, албан газрын нэрийг бичнэ.
 - 6.2.2.2. Аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэх үед мэдээллийг хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.
 - 6.2.2.3. Металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн байна.



Зураг 3. Байршлын мэдээллийн самбар. /Жишээ/

6.3. Барилга байгууламжийн мэдээллийн самбар


- 6.3.1. Барилгын ажил явагдаж байгаа дэвсгэр нутаг болон барилга объектын талбайг барилга угсралтын ажил явагдаж байгаа хугацаанд хамгаалах, гадны хүн нэвтрүүлэхгүй байх, хүмүүст сэрэмжлүүлэх зорилготой барилгын түр хашаан дээр байрлуулсан самбарыг хэлнэ.
- 6.3.2. Барилга байгууламжийн түр мэдээллийн самбарыг “Барилга, замын ажил гүйцэтгэхэд иргэдийн аюулгүй байдлыг хангах ерөнхий шаардлага” UCS 0301В-д заасны дагуу төлөвлөвөл зохино.
- 6.3.3. Барилгын мэдээллийн самбарт дараах мэдээллүүдийг тусгана. Үүнд:
 - 6.3.3.1. Тухайн барилга байгууламжийн захиалагч, ерөнхий гүйцэтгэгчийн нэр;
 - 6.3.3.2. Батлагдсан ерөнхий төлөвлөгөө, талбайн зохион байгуулалтын зураг;
 - 6.3.3.3. Барилгын ажил эхлүүлэх зөвшөөрлийн гэрчилгээний зураг;
 - 6.3.3.4. Барилгын эхлэх болон дуусах хугацааг тодорхой бичиж яаралтай үед холбогдох талбайн ерөнхий инженер, талбайн хөдөлмөр аюулгүй байдлыг хариуцсан инженерийн нэр, холбоо барих утасны дугаарыг тэмдэглэнэ.



Зураг 4. Барилга байгууламжийн мэдээллийн самбар

6.4. Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн самбар


- 6.4.1. Нийтийн тээврийн маршрут заасан самбар гэж тухайн буудалд ирэх нийтийн тээврийн хэрэгслийн зорчих маршрут болон, хугацааг заасан цогц самбарыг хэлнэ.
- 6.4.2. Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоол, буудал дахь байгууламжууд нь орчиндоо зохицсон, эрх бүхий байгууллагын батлагдсан зураг төслөөр, өнгө үзэмжтэй гэрэлтүүлэгтэй хийгдсэн байх шаардлагатай
- 6.4.3. Мэдээллийн самбар дээрх мэдээлэл нь өдөр шөнийн аль ч цагт уншигдахаар байх ба дараах мэдээллийг багтаасан байна.
 - 6.4.3.1. Автобусны зогсоолын нэр;
 - 6.4.3.2. Үйлчилгээний цагийн хуваарь, хүлээх цагийн давтамж;
 - 6.4.3.3. Маршрутын дугаар, маршрутын зураглал
 - 6.4.3.4. Тасалбарын үнэ (зөвхөн хот хоорондын автобус);
 - 6.4.3.5. Нийтийн тээврээр үйлчлүүлэхтэй холбогдсон аяллын мэдээллүүд;
 - 6.4.3.6. Шаардлагатай үед нийтийн тээврийн автобусны зогсоолын түр өөрчлөлт орж буй талаарх нэмэлт өөрчлөлт орж буй талаарх нэмэлт мэдээлэл
- 6.4.4. Нийтийн тээврийн автобус зогсоолд ирэх нийтийн тээврийн хэрэгслийн зорчих маршрут болон, хугацааг заасан цогц самбарыг хэлэх ба байрлуулах, суурилуулах зааврыг “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавигдах шаардлага” UCS 1601B-д заасны дагуу төлөвлөвөл зохино.



Зураг 5. Нийтийн тээврийн үйлчилгээний мэдээллийн самбар

6.5. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар

- 6.5.1. Түүхэн соёл, дурсгал газрын танилцуулга гэж соёлын өвийг хадгалж хамгаалах, сэргээн засварлах, судлах, сурталчлах, ашиглах талаар аялал жуулчлалын чиглэлд зориулсан тухайн газрын онцлог бүхий түүх, домог зэргийг бичиж сийрүүлсэн мод, чулуу, төмөр хийцлэлээс бүтсэн байгууламжийг хэлнэ.
- 6.5.2. Тогтсон стандарт хэмжээ заахгүй бөгөөд архитектур талаасаа тухайн газрын уур амьсгалд нийцсэн, загвар, өнгө үзэмжтэй байна.



Зураг 6. Түүх, аялал жуулчлалын холбогдолтой мэдээллийн самбар

7. МЭДЭЭЛЛИЙН САМБАРТ ТАВИГДАХ ШААРДЛАГА

Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах мэдээллийн байгууламжийн бичвэрийн агуулга, зураг дүрслэлийн ойлгомжтой байдалд онцгойлон анхаарч боловсруулах шаардлагатай бөгөөд дараах нийтлэг шаардлага тавигдана. Үүнд:

7.1. Бичвэрийн шаардлага

- 7.1.1. Гадна мэдээллийн байгууламжийн бичвэрийг Монгол Улсын засгийн газрын 2013 оны 37 дугаар тогтоолын 5 дахь заалтын дагуу Монгол хэл /кирилл/-ээр үг, үсгийн алдаагүй бичих ба Монгол бичиг /уйгуржин/-ээр бичиж болно.
- 7.1.2. Шаардлагатай нөхцөл /бараа, бүтээгдэхүүний нэр, лого нь зохиогчийн эрхээр баталгаажсан, гадаадын иргэд олноор үйлчлүүлдэг/-д гадна хаяг, мэдээллийн байгууламжийн бичвэрийг англи хэлээр бичих ба бичвэр нь монгол бичвэрийн доод талд байрлаж, түүнээс 2 дахин бага өндөртэй байх эсвэл монгол /кирилл/ бичвэрийн зүүн гар талд байрлаж, түүнтэй ижил өндөртэй байна.
- 7.1.3. Мэдээллийн байгууламжийн нийт овор хэмжээ нь жигд өндөрт байрлаж, ижил өнгийн дэвсгэр дээр хийгдэх ба лого болон бичвэрийг тус тусын үйл ажиллагааны онцлогт нийцүүлэн байрлуулна.
- 7.1.4. Аль нэг байгууллага солигдох, мэдээлэл нь шинэчлэх үед мэдээллийг хялбар өөрчилж болох шийдэлтэй байна.

7.2. Зураглалын шаардлага

- 7.2.1. Нийтийн эзэмшлийн мэдээллийн байгууламжид байрлуулах зураглалд дараах гэрэл зураг, график зураглал, газрын зургийн шаардлага тавигдана. Үүнд:

Дүрс, тэмдэг – Хялбаршуулсан жижиг график зургууд нь агуулж буй мэдээллийн ойлголтуудыг богино хугацаанд ойлгогдохоор хялбаршуулсан дүрслэн харуулсан тэмдэг, тэмдэглэгээ байна.

Зураг, зураглал – Зураг дүрслэлийг мэдээлэлд ашиглах нь нэмэлт текстийг хэмнэж, утга агуулгыг сайн ойлгоход туслах бөгөөд, энгийн дүрсэлсэн агуулгатай байна.

Газрын зураг – Тухайн байршил, эхлэх цэгээс очих газрын маршрут, явганаар болон тээврийн хэрэгслээр туулах замын урт, хугацаа зэргийг үзүүлж, орон зайн хэмжээс болон түүний бодит хэмжээсний харьцааг ойлгогдохуйцаар илэрхийлж, чухал шаардлагатай барилга байгууламж үйлчилгээний мэдээллийг таних тэмдэг тайлбартайгаар үзүүлж, зүг чигийн сумыг байрлуулсан байна.

7.3. Дизайн, технологийн шаардлага

- 7.3.1. Нийтийн эзэмшлийн талбайд байршуулах мэдээллийн байгууламжийн загвар дизайныг тухайн орчны барилга байгууламжийн архитектурын онцлог, өнгө үзэмжид тохируулан гоёмсог загвар хийцтэйгээр хийж, нэг гудамжинд байрлуулах мэдээллийн байгууламжийн шинж чанарыг онцгойлон анхаарах шаардлагатай.

- 7.3.2. Гадна мэдээллийг байгууламжийг байрлуулах барилгын даац, гадна фасадын бүрэн бүтэн байдлыг алдагдуулахгүй байхын зэрэгцээ хууль ёсны эзэмшигч, ашлагч нараас албан ёсоор зөвшөөрөл авсан байна.
- 7.3.3. Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь хотын өнгө үзэмжид нийцсэн, орчин үеийн технологийн шийдлийг ашигласан байх ба засвар, үйлчилгээг тогтмол хийж, бүрэн бүтэн байдлыг хангуулна.
- 7.3.4. Нийтийн эзэмшлийн мэдээллийн байгууламж нь явган хүний эргономик, тээврийн хэрэгслээр зорчигчид болон хөгжлийн бэрхшээлтэй хүний хүртээмжтэй байдлын шаардлагыг хангасан байна.
- 7.3.5. Гадна хаяг, мэдээллийн байгууламж нь гадна эсвэл дотор гэрэлтүүлэгтэй байна.
- 7.3.6. Цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримталсан байна.

7.4. Нэмэлт медиа тоноглол


- 7.4.1. Хотын оршин суугч бүрд тэгш хүртээмжтэй мэдээллийг үр дүнтэй, амар хялбараар хүргэх дуу, дүрс болон ухаалаг мэдрэгчтэй дэлгэцээр тоноглогдсон мэдээллийн байгууламжаар дамжуулан явуулын хүмүүст хамааралтай тохирсон контент бүхий олон төрлийн үйлчилгээ үзүүлж болно.




Зураг 7. Ухаалаг мэдээллийн байгууламж

8. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖ БАЙРЛУУЛАХ

- 8.1. Гадна мэдээллийн байгууламжийг явган хүний замд саад учруулахгүй, авто замын уулзваруудын хажууд, нийтийн тээврийн зогсоол, нийтийн үзвэр үйлчилгээний газар, нийтийн бие засах газар зэрэг нийтийн эзэмшлийн талбайд байршуулбал зохистой.
- 8.2. Гадна хаяг, мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн гудамж, талбайд байрлуулах нөхцөлд дараах хэм хэмжээг баримтална. Үүнд:
- 8.2.1. Автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчин хязгаарлахгүй байх;
- 8.2.2. Автозамын хэвтээ проекцоос 1 метрээс багагүй зайд байрлуулах бөгөөд авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй байх (MNS 4596: 2014).
- 8.2.3. Барилгын хана, фасад дээвэрт байрлах нөхцөлд тухайн барилга болон хөрш зэргэлдээ объектын цонх, хаалга, үзэгдэх орчинг халхлахгүй байх;
- 8.3. Нэг барилгад үйл ажиллагаа явуулж буй хэд хэдэн байгууллагын гадна хаяг, мэдээллийн байгууламжийг нийтийн эзэмшлийн талбайд байрлуулахаар бол бүх байгууллагын мэдээллийг агуулсан нэгдсэн мэдээллийн байгууламжийг тухайн барилгын эзэмшигч, өмчлөгчийн зүгээс байрлуулна.
- 8.4. Гадна мэдээллийн байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлахгүй байх ёстой. Зай хэмжээний шаардлагыг Зураг 8 -т үзүүлэв.



Зураг 8. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага




Зураг 9. Мэдээллийн байгууламжийн зай хэмжээний шаардлага

- 8.5. Хэрэв барилга нь замаас хол зайтай бол хоёр самбартай байх нь зүйтэй бөгөөд, нэг нь замын ойролцоо тойм мэдээллийг унших боломжтой, нөгөө нь барилгын үүдний ойролцоо илүү дэлгэрэнгүй мэдээллийг харуулдаг байвал зохино.
- 8.6. Эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр нийтийн эзэмшлийн зам, талбай болон бүх төрлийн өмчийн хэлбэрийн барилга байгууламж холбоо, цахилгаан, гэрэлтүүлгийн шон зэрэгт мэдээллийн байгууламж байрлуулахыг хориглоно.
- 8.7. 1 ба 2 дугаар зэрэглэлийн гудамж талбайд авто замын тусгаарлах зурвасаас бусад газар 3х6 м-ээс том самбар тавихыг хориглоно.
- 8.8. Иргэд оршин суугчид, бусад байгууллагуудын цонх харагдах орчныг халхалж, байгалийн гэрэл ашиглах боломжийг хязгаарлахгүй байвал зохино.

9. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖ СУУРИЛУУЛАХ

- 9.1. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулахдаа орчны аюулгүй байдлыг хангах зорилгыг урьтал болгоно.
- 9.2. Гадна мэдээллийн байгууламжийг газарт хөдөлгөөнгүй суурилуулах бөгөөд суурийн бетон эдлэлд зөвхөн тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлнэ.
- 9.3. Гадна мэдээллийн байгууламжийн үндсэн хийц эдлэхүүний нийт жингээс хамааруулан суурийн бетон эдлэлийн хэмжээг тооцно.
- 9.4. Гадна мэдээллийн байгууламжийн багана болон бусад холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх ёстой бөгөөд гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 9.5. Мэдээллийн самбарыг нийтийн эзэмшлийн талбай гудамжинд суурилуулахдаа ногоон байгууламжийн мод, бутны хэмжээ, тэдгээрийн байршил, ургалтын хэв маягийг анхаарах хэрэгтэй.



Зураг 10. Гадна мэдээллийн байгууламжийг суурилуулах хэсэгзлэл. /Жишээ /

10. МАТЕРИАЛ, БҮТЭЭЦИЙН ШААРДЛАГА







10.1. Мэдээллийн байгууламжийн металл хийц хэсгүүдийг зэвэрдэггүй материалаар хийх, аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэгийг стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна. Мэдээллийн байгууламжид тохирох өнгөний сонголтыг Хүснэгт 1 -т үзүүлэв.




Хүснэгт 1. Мэдээллийн байгууламжийн эдлэхүүний өнгөний төрөл

№	Нэр, тэмдэглэгээ	Өнгө	Өнгөний код /CMYK/
1	Мөнгөлөг RAL9006		C – 15, M – 10, Y – 10, K – 0
2	Цайвар саарал RAL7046		C – 30, M – 10, Y – 0, K – 0
3	Саарал RAL9001		C – 25, M – 20, Y – 50, K – 0
4	Цагаан		C – 0, M – 0, Y – 0, K – 0
5	Хар		C – 0, M – 0, Y – 0, K – 100

МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН МЕТАЛЛ ХИЙЦЛЭЛ МАТЕРИАЛЫН ТӨРӨЛ, ҮЗҮҮЛЭЛТ

Хүснэгт 2. Хийцлэлийн төрөл, үзүүлэлт

№	Материалын нэр	Төрөл, марк	Зузааны хэмжээ	Огтлолын хэмжээ, мм	Ханын зузааны хэмжээ, мм	Хүндийн хэмжээ, м/кг
1	Дөрвөлжин металл яндан			A=30x30	S=1.5-2.0	1.07-1.39
2	Дөрвөлжин металл яндан			A=50x50	S=1.5-2.5	0.64-1.5
3	Тэгш өнцөгт металл яндан			A=40x25	S=1.5-2.5	0.64-1.5
4	Тэгш өнцөгт металл яндан			A=60x30	S=1.5-2.5	1.07-2

5	Зууван металл яндан			A=45x28 A=38x25	S=1.5-2.5	1.32-1.73
6	Дугуй металл			D=50		1.13-3.5

11. БҮРТГЭЛ, АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ

- 11.1. Нийтийн эзэмшилд байрлуулсан, гадна мэдээллийн самбарыг өмчлөгч, ашиглагч байгууллага бүртгэх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх, ашиглах журмыг мөрдлөг болгоно.
- 11.2. Мэдээллийн самбарын бохирдол, элэгдэл, эвдрэлээс шалтгаалан иргэдэд осол гэмтэл учруулах болзошгүй нөхцөл байдлыг үнэлж байнгын хяналт, үнэлгээ хийж цэвэрлэгээ, засвар үйлчилгээг тогтмол хийнэ.
- 11.3. Мэдээллийн самбарыг зүй бусаар ашиглах, хохирол учруулах, сүйтгэх, устгах, гэмтээх, зүй зохисгүйгээр ашиглахыг хориглоно.
- 11.4. Гадна мэдээллийн самбарт хяналт үнэлгээ хийх чиглэлийг Хүснэгт 3 -т үзүүлэв.

Хүснэгт 3. Мэдээллийн байгууламжид хяналт, үнэлгээ хийх чиглэл

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Бохирдолтой эсэх	☐	☐
2	Мэдээллийн самбар бүрэн бүтэн эсэх	☐	☐
3	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан эсэх	☐	☐
4	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	☐	☐
5	Гэрэлтүүлэг бүрэн бүтэн ажиллаж байгаа эсэх	☐	☐

Тайлбар: Мэдээллийн байгууламжийн ашиглалтын нөхцөл байдал нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “**Тийм**” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “**Үгүй**” хэсгийг тэмдэглэнэ.

12. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН САМБАРЫГ ХҮЛЭЭН АВАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Гадна мэдээллийн байгууламжид тавигдаж байгаа материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, загвар, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг хүлээн авах шалгуур үзүүлэлт (Хүснэгт 4.) -ийн дагуу хянан шалгаж хүлээн авна.

Хүснэгт 4. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулсан мэдээллийн байгууламж нь автомашин болон явган хүний хөдөлгөөнд саад учруулахгүй, үзэгдэх орчныг хязгаарлаагүй эсэх	☐	☐
2	Мэдээллийн байгууламж нь замын хөдөлгөөний болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хяналтын камер, хөдөлгөөн зохицуулах гэрэл дохио, авто замын тэмдгийн үзэгдэх орчныг халхлаагүй эсэх	☐	☐
3	Авто замын байгууламжийн хэвтээ проекцоос 1 метрийн зайтай эсэх	☐	☐
4	Мэдээллийн байгууламж нь гудамж зам талбай, барилгын загвар дизайнд тохирсон үзэмжтэй байх	☐	☐
5	Мэдээллийн байгууламжийг инженерийн дэд бүтцийн шугам сүлжээний хамгаалалтын зурваст байрлуулаагүй эсэх	☐	☐
6	Мэдээллийн байгууламжийн металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн аль эсвэл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	☐	☐
7	Мэдээллийн байгууламж нь гадна, эсвэл дотор гэрэлтүүлэгтэй эсэх	☐	☐
8	Цахилгаан болон барилга угсралтын аюулгүй ажиллагааны талаарх холбогдох норм, стандартыг баримталсан эсэх	☐	☐
9	Мэдээллийн байгууламжийг газарт хөдөлгөөнгүй бэхэлж, тэлэгч боолт ашиглаж газрын гадаргад бэхэлсэн эсэх	☐	☐

Тайлбар: Нийтийн эзэмшлийн талбайд байрлуулах мэдээллийн байгууламж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

ХАВСРАЛТ №1 НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИЙН ДИЗАЙН



Зураг 11. Мэдээллийн байгууламжийн загвар. / Жишээ /

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Нийслэлийн нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгаа байрлуулахад дагаж мөрдөх журам /Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн 9/10 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралт/
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийн хаягийн тэмдэглэгээнд тавих ерөнхий Нийтийн тээврийн зогсоолын төлөвлөлт БД 32-101-17
- Барилгын үйлдвэрлэлд дагаж мөрдөх хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм БНБД 12-03-04
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам /Засгийн газрын 2019 оны 325 дугаар тогтоолын хавсралт/
- Гудамж, зам, талбай, үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам
- Хаяг, Хаягийн бичвэрт тавигдах ерөнхий шаардлага MNS 6775:2019
- Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын дүрэм ЭХД-2-20-01-2013
- Цахилгаан техникийн байгууламжийн угсралтын аюулгүй ажиллагааны дүрэм ЭХД-1-12-04-2013
- Монгол кирилл үсгийн латин хөрвүүлэг MNS 5217:2017



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ОРЧНЫ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
ХЯНАЛТ ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР



Хангарди ордон, Ц.Жигжиджавын гудамж -7/1
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160-0011



7011-8060



www.standart.ub.gov.mn



Хотын стандарт, орчны аюулгүй байдлын хяналт,
зохицуулалтын газар